

**ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН-ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДААР ТОМИЛУУЛАХ
САНАЛЫН ТАЛААР НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 12 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн З.Баянсэлэнгэ**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг Засгийн газрын гишүүн-Эрүүл мэнд, спортын сайдаар Ганхуягийн Шийлэгдамбыг томилуулах тухай саналаа 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, 37.6 дахь хэсэгт заасныг үндэслэн Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2014 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Ерөнхий сайдын дээрх саналыг хэлэлцлээ.

Эрүүл мэнд, спортын сайдад нэр дэвшигч Г.Шийлэгдамба нь 1992 онд Өвөрхангай аймгийн 10 жилийн дунд сургууль, 1996 онд “Цог” гадаад хэлний дээд сургууль, 1998 онд Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институт, 2012 онд Австрали Улсын Чарлис Стюрт их сургуулийг тус тус суралцаж төгссөн.

Г.Шийлэгдамба нь 1996-1997 онд “Цог” гадаад хэлний дээд сургуульд багш, 1997-2000 онд “Баянговь жуулчин” ХХК-ний захирал, 2000-2004 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Аялал жуулчлалын газрын дарга, 2004-2007 онд Зам тээвэр, аялал жуулчлалын дэд сайд, 2007-2008 онд Байгаль орчны сайд, 2012 оноос МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар тус тус ажиллаж байна.

Байнгын хорооны хуралдааны үед Улсын Их Хурлын гишүүн Г.Баярсайхан, Ё.Отгонбаяр нар Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийг хэрхэн хийх, холбогдох хууль, тогтоолуудыг хэзээ өргөн мэдүүлэх талаар асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн З.Баянсэлэнгэ, Ж.Батсуурь, Ё.Отгонбаяр, С.Одонтуяа нар эрүүл мэндийн салбарт улс төрчдийн оролцоо их байгааг сануулав. Мөн Улсын Их хурлын гишүүн Д.Батцогт, Г.Баярсайхан, С.Одонтуяа, Л.Эрдэнэчимэг нар эрүүл мэндийн салбарын төсөв, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, царцаагдсан барилгын ажлыг шуурхай шийдвэрлэхэд анхаарах, эрх зүйн шинэчлэл хийх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Оюунгэрэл спортыг аялал жуулчлалтай хөгжүүлснээс үүдэн явган аялал, марафон гүйлт, нийтийн бүжгийн амжилт өссөн тул цаашид хөгжүүлэх нь зүйтэй зэрэг саналыг хэллээ.


Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрүүл мэнд, спортын сайдад нэр дэвшигч Г.Шийлэгдамбыг томилуулах саналыг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэй дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын гишүүн- Эрүүл мэнд, спортын сайдад нэр дэвшигч, Г.Шийлэгдамбын талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Д.БАТЦОГТ